



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/148/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сайншанд сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2020.02.04 № 16/105

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГАЛБА-ӨӨШ, ДОЛООДЫН  
ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Б.ЯЛАЛТБАЯР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.



Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3.9	7.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	548.3	438.0
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>552.2</b>	<b>445.7</b>
	Нийт өр төлбөрийн дүн		-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	552.2	445.7
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>552.2</b>	<b>445.7</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	293.0	257.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	276.6	364.1
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>16.4</b>	<b>(106.5)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>16.4</b>	<b>(106.5)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535.8	552.2
	Тайлант оны үр дүн	16.4	(106.5)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>552.2</b>	<b>445.7</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	205.4	257.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	195.9	257.2
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>9.5</b>	<b>0.4</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(9.5)</b>	<b>0.4</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>159.4</b>	<b>179.3</b>
	Урсгал зардал	159.4	179.3
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>180.5</b>	<b>206.9</b>
	Улсын төсвөөс санхүүжих	180.5	206.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	0.1

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Монгол орны зүүн өмнөд бүсийн 4 аймаг 23 сумын 143.2 мянган км.кв талбай бүхий өргөн газар нутагт усны бодлогын асуудал, усны нөөц, мэдээллийн сан бүрдүүлэх ажлуудыг хариуцан ажилладаг төрийн захиргааны байгууллага юм. Хамрагдах аймаг, сумд:

- Өмнөговь аймгийн 7 сум; Баян-Овоо, Номгон, Ханбогд, Цогтцэций, Манлай, Хүрмэн, Ханхонгор;
- Дорноговь аймгийн 9 сум; Мандах, Хатанбулаг, Сайхандулаан, Хөвсгөл, Сайншанд, Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Замын-Үүд;
- Сүхбаатар аймгийн 5 сум; Баяндэлгэр, Онгон, Дарьганга, Асгат, Наран;
- Дундговь аймгийн 1 сум; Өлзийт сум багтдаг.

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гол мөрөн, нуур усны эх үүсвэр болон газрын доорх усны цэнгэг орд газруудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулах.
- Сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах.
- Хоногт 50-100 шоо метр ус ашиглах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, ус болон усан орчин ашиглуулах дүгнэлт гаргах.
- Сав газар дахь хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллагад ус ашиглах зөвшөөрөл олгох.
- Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах иргэн, аж ахуй нэгж, байгууллагад ус ашиглах зөвшөөрөл олгох.
- Ус ашигласны болон бохирдуулсан төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ноогдуулах, үндэслэлийг тодорхойлох.
- Усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах.
- Ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх, суваг хоолой татах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч усны нөөцийн нэгдсэн менежмент төлөвлөгөөг үндэслэн ус ашиглуулах дүгнэлт гаргах, мэдээллийн санд оруулах.

Тус байгууллага нь эрхэм зорилгоо “Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ус бохирдуулсан төлбөрийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оршино” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны жилийн эцэст тус байгууллагын төсөв захирагч өндөр насны тэтгэвэрт гарсан ба 2022 оны 02 дугаар сард дараагийн төсөв захирагч томилогдсон тул Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын газарт төсөв захирагчийн гарын үсэггүй ирүүлсэн болно.

#### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 5 уст цэгийн ГӨД нэртэй онлайн 247.7 сая төгрөгийн 5 төхөөрөмж, байгуулж бүртгэлтэй байна. Эдгээрээс 3 төхөөрөмжийн 8 хэрэгсэл /нарны зайн панель, аккумулятор гэх мэт/ алдагдсан ба хэрэгслийг бүртгэлд тусад нь үнэлээгүй тул алдагдсан хөрөнгийн үнэлгээ тодорхойгүй байна. Алдагдсан хөрөнгийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, хэрэг үүсгэх талаар цагдаагийн байгууллагад хандсан боловч тодорхой шийдвэр гараагүй байна.

Тус байгууллагын хариуцах асуудлын хүрээний онлайн бус уст цэгүүд нь бүртгэлд тусгагдаагүй байна. Уст цэгийн үнэлгээ болон бүртгэлд тусгах асуудлаар дээд шатны байгууллагаас шийдвэр ирээгүй байна.

Тайлант онд усны чанар, сөрөг нөлөөллийн үнэлгээ хийлгэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж, Өнө мөнхийн ундарга төв НҮТББ шалгарч, 42.6 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэсэн байна.

#### **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 255.9 сая төгрөгийн орлогын 15 гүйлгээ, 73.4 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, 52.3 сая төгрөгийн 2 худалдан авах ажиллагааны мэдээлэл, төсөв, хөрөнгө зарцуулах 62.4 сая төгрөгийн 22 тушаалыг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 1.3 сая төгрөгийн 4 тушаалыг хугацааг хоцроож байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, худалдан авах ажиллагааны мэдээллийг тогтоосон цаг хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайланг мөн шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

#### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус байгууллага нь хоногт 50-100 м.куб ус ашиглах байгууллагад дүгнэлт гаргах үйлчилгээг үзүүлдэг ба БОАЖ-ын сайдын 2018 оны А/376 дугаар тушаалын дагуу 100.0 мянган төгрөгийн төлбөрийг үйлчилгээний хөлсөнд авдаг байна. Тиймээс ус ашиглах дүгнэлтийн тоо болон үйл ажиллагааны орлогыг тулгах шалгах нь зүйтэй.

#### **Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар үнийн дүнгүй 2 алдаа зөрчил илэрч, аудитын явцад 1 алдааг залруулж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

**Залруулсан алдаа:** Албан хаагчдын цалингаас суутгасан 51.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шийтгэл, хувь хүний орлогын албан татвар, цалингийн урьдчилгаа болон бусад суутгалыг цалингийн өглөг дансанд тусгахгүйгээр бүртгэсэн байна.

**Зөвлөмж:** Тус байгууллагын дансанд 5 онлайн уст цэгийн байгууламж, тоног төхөөрөмж бүртгэлтэй байна. Уг байгууламж нь харуул хамгаалалтгүй, хөдөө сумдад байрладаг учир барилгын гадна байрлах тоног төхөөрөмж алдагдсан байна. Өмнөговь аймгийн Ханбогд сум, Дорноговь аймгийн Сайншанд суманд байрлах уст цэгийн нарны антенн, панель зэрэг нийт 8 хэрэгсэл алдагдсан байна. Эдгээр хөрөнгө нь байгалийн үзэгдлийн улмаас хийссэн, эсхүл хулгайд алдагдсан нь тодорхойгүй байна. Харьяа аймаг, сумын цагдаагийн байгууллагад шалгуулах хүсэлт өгсөн боловч зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Эдгээр хөрөнгө нь байгууллагын санхүүгийн тайланд байгууламж нэрээр нийт дүнгээр бүртгэгдсэн ба алга болсон хөрөнгө нь тусдаа бүртгэлгүй байна.

Иймд уст цэгүүдийн байршилд байрлах байгууламж, тоног төхөөрөмжийн алдагдсан, алга болсон хөрөнгийн үнэлгээг тогтоон, бүртгэлээс хасах, нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх. Хөдөөгийн сумдад байрлах хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарч, арга хэмжээ авч ажиллах.

### 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	1	1			1			

### 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	-	1	-	-	-	-	-	1	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	<b>НИЙТ</b>	2	-	1	-	-	-	-	-	1	-